



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Номын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ОРА-2022/79/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Эрдэнэт хот 2022 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Ц.Нармандах Утас: 70359826 Цахим хаяг: orkhon@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Б.Эрдэнэ Утас: 70355805 Цахим хаяг: orkhon@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Б.Буян-Ундрах Утас: 70357955 Цахим хаяг: orkhon@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
3. Аудитын тайлан	9
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	11
3.8 Аудитын гол асуудал	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	12
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	12
4. Аудитын илрүүлэлт	12
4.1 Залруулсан алдаа	12
4.2 Төлбөрийн акт	13
4.3 Зөвлөмж.....	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	14

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.Аудитын санал дүгнэлт



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2022.02.25 № 79
танай _____-ны № _____-г

ОРХОН АЙМГИЙН НОМЫН
ТӨВИЙН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Д.ЦЭНД-АЮУШ
ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Номын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Номын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

D:\my doc \alban bichig\ 2022-A4.doc

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

ДАНС	Үзүүлэлт	Үлдэгдэл	ГҮЙЦЭТГЭЛ
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	6,238,122.00	4,920,322.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	2,396,222.00	396,222.00
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	2,396,222.00	396,222.00
31130	Нэмэлт санхүүжилт	2,396,222.00	396,222.00
35	БАРАА МАТЕРИАЛ	3,841,900.00	4,524,100.00
351	Түүхий эд материал	3,662,200.00	4,344,400.00
35110	Тусгай зориулалттай материал	3,662,200.00	4,344,400.00
354	Хангамжийн материал	179,700.00	179,700.00
35420	Аж ахуйн материал	179,700.00	179,700.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	948,471,014.15	969,846,645.74
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	948,471,014.15	969,846,645.74
392	Биет хөрөнгө	831,636,014.15	848,586,645.72
39201	Барилга, байгууламж, орон сууц	690,634,289.00	736,466,132.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(36,819,478.05)	(64,863,453.21)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	21,000,000.00	21,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(21,000,000.00)	(21,000,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	58,165,372.00	57,582,492.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(51,964,937.31)	(51,033,118.27)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	37,613,122.52	36,498,793.32
39208	Хуримтлагдсан элэгдэл	(31,789,710.01)	(33,179,704.12)
39217	Ном	165,797,356.00	167,115,504.00
393	Биет бус хөрөнгө	116,835,000.00	121,260,000.02
39301	Програм хангамж	6,180,000.00	11,180,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(5,955,000.00)	(6,529,999.98)
39303	Бусад биет бус хөрөнгө	116,610,000.00	116,610,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	954,709,136.15	974,766,967.74
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	954,703,136.15	974,766,967.74
51	Засгийн газрын хувь оролцоо	954,703,136.15	974,766,967.74
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	370,872,729.52	370,872,729.52
51101	Өмч: - төрийн	370,872,729.52	370,872,729.52
512	Хуримтлагдсан үр дүн	150,306,712.11	170,370,543.70
51210	Өмнөх үеийн үр дүн	169,389,360.74	150,312,712.11
51220	Тайлант үеийн үр дүн	(19,082,648.63)	20,057,831.59
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	433,523,694.52	433,523,694.52
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	954,703,136.15	974,766,967.74

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ГҮЙЦЭТГЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	357,420,068.00	350,607,243.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,234,468.00	52,311,843.00
120	Нийтлэг татварын бус орлого	3,995,620.00	49,446,343.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,995,620.00	3,614,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,966,120.00	3,614,500.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	29,500.00	-
120009	Бусад орлого	-	45,831,843.00
122	Тусламжийн орлого	2,238,848.00	2,865,500.00
122001	Хандив тусламж /дотоод/	2,228,848.00	2,865,500.00
122002	Хандив тусламж /гадаад/	10,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	351,185,600.00	298,295,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	16,718,800.00
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	-	1,250,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	15,468,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	351,185,600.00	281,576,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	346,185,600.00	281,576,600.00
132002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	5,000,000.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	376,502,716.63	330,180,560.10
21	УРСГАЛ ЗАРДАЛ	376,502,716.63	330,180,560.10
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	309,064,361.90	324,064,670.49
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	222,472,013.00	214,732,392.00
210101	Үндсэн цалин	53,444,492.00	37,412,560.00
210102	Нэмэгдэл	154,220,121.00	162,095,909.00

**Номын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,807,400.00	15,223,923.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,395,981.27	27,871,518.39
210201	Тэтгэврийн даатгал	19,504,145.19	19,289,058.37
210202	Тэтгэмжийн даатгал	2,222,959.02	2,145,616.97
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,778,367.22	1,716,490.05
210204	Ажилгүйдлийн даатгал	444,591.80	429,119.06
210205	Эрүүл мэндийн даатгал	4,445,918.04	4,291,233.94
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,227,561.00	23,719,200.00
210301	Гэрэл, цахилгаан	3,558,615.00	5,762,500.00
210302	Түлш, халаалт	14,903,946.00	13,906,500.00
210303	Цэвэр, бохир ус	2,765,000.00	4,050,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,518,860.00	2,010,600.00
210401	Бичиг хэрэг	1,075,600.00	630,600.00
210402	Тээвэр, шатахуун	750,000.00	330,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,417,760.00	1,050,000.00
210404	Ном, хэвлэл	150,000.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	96,000.00	-
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	29,500.00	-
2105	Нормативт зардал	851,300.00	551,700.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	475,800.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	375,500.00	551,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,095,700.00	3,324,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	685,000.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	186,800.00	-
210604	Урсгал засвар	1,223,900.00	3,324,300.00
2107	Томилт, зочны зардал	297,600.00	324,600.00
210702	Дотоод албан томилт	297,600.00	324,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,462,650.00	16,391,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,316,000.00	15,371,400.00
210807	Газрын төлбөр	-	1,020,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	146,650.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,742,696.63	35,138,960.10
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	25,742,696.63	35,138,960.10
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	67,438,354.73	6,115,889.61
2132	Бусад урсгал шилжүүлэг	55,312,500.00	3,938,300.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	-	68,300.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	52,082,500.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,230,000.00	3,870,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	2,177,589.61
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	2,177,589.61
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(19,082,648.63)	20,426,682.90
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	368,851.31
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	368,851.31
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(368,851.31)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(19,082,648.63)	20,057,831.59

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

	ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	370,872,729.52	433,523,694.52	169,389,360.74	973,785,784.78
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	370,872,729.52	433,523,694.52	169,389,360.74	973,785,784.78
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(19,082,648.63)	(19,082,648.63)
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	370,872,729.52	433,523,694.52	150,306,712.11	954,703,136.15
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	370,872,729.52	433,523,694.52	150,306,712.11	954,703,136.15
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	6,000.00	6,000.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	370,872,729.52	433,523,694.52	150,312,712.11	954,709,136.15
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	20,057,831.59	20,057,831.59
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	370,872,729.52	433,523,694.52	170,370,543.70	974,766,967.74

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ГҮЙЦЭТГЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	356,531,720.00	306,265,251.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,966,120.00	3,614,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	3,966,120.00	3,614,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,966,120.00	3,614,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,966,120.00	3,614,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	352,565,600.00	302,650,751.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	16,718,800.00
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	-	1,250,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	15,468,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	351,185,600.00	281,576,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	346,185,600.00	281,576,600.00
132002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	5,000,000.00	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,380,000.00	4,355,351.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	1,380,000.00	4,355,351.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	352,575,400.00	300,079,151.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	352,575,400.00	300,079,151.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	283,781,365.27	289,607,910.39
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	222,722,994.27	214,461,382.00
210101	Үндсэн цалин	167,046,275.00	157,695,956.00
210102	Нэмэгдэл	46,410,636.74	41,912,234.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,266,082.53	14,853,192.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,145,000.00	28,142,528.39
210201	Тэтгэврийн даатгал	19,138,600.00	20,440,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,251,600.00	2,151,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,801,300.00	1,721,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	450,300.00	430,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,503,200.00	3,399,128.39
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,227,561.00	23,719,200.00
210301	Гэрэл, цахилгаан	3,558,615.00	5,762,500.00
210302	Түлш, халаалт	14,903,946.00	13,590,500.00
210303	Цэвэр, бохир ус	2,765,000.00	4,366,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,321,160.00	2,692,800.00
210401	Бичиг хэрэг	1,075,600.00	630,600.00
210402	Тээвэр, шатахуун	750,000.00	330,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,417,760.00	1,050,000.00
210404	Ном, хэвлэл	906,000.00	682,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	171,800.00	-
2105	Нормативт зардал	775,500.00	551,700.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	400,000.00	176,200.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	375,500.00	375,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,828,900.00	3,089,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	685,000.00	89,700.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	500,000.00	500,000.00
210604	Урсгал засвар	643,900.00	2,500,000.00
2107	Томилт, зочны зардал	297,600.00	324,600.00
210702	Дотоод албан томилт	297,600.00	324,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,462,650.00	16,626,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,350,000.00	15,606,000.00
210807	Газрын төлбөр	966,000.00	1,020,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	146,650.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	68,794,034.73	10,471,240.61
2132	Бусад урсгал шилжүүлэг	56,692,500.00	3,938,300.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	1,380,000.00	68,300.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	52,082,500.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,230,000.00	3,870,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	4,355,351.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	4,355,351.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	12,101,534.73	2,177,589.61
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,101,534.73	2,177,589.61
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	3,956,320.00	6,186,100.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	5,462,000.00	8,186,100.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,462,000.00	8,186,100.00
2200	Дотоод эх үүсвэрээр	5,462,000.00	8,186,100.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	5,462,000.00	8,186,100.00

**Номын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(5,462,000.00)	(8,186,100.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(1,505,680.00)	(2,000,000.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,901,902.00	2,396,222.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,396,222.00	396,222.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	281,576,600.00	272,462,910.39
21	УРСГАЛ ЗАРДАЛ	281,576,600.00	272,462,910.39
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	281,076,600.00	271,962,910.39
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	215,160,000.00	214,461,382.00
210101	Үндсэн цалин	158,355,500.00	157,695,956.00
210102	Нэмэгдэл	40,928,500.00	41,912,234.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,876,000.00	14,853,192.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,046,600.00	28,142,528.39
210201	Тэтгэврийн даатгал	20,440,200.00	20,440,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,151,600.00	2,151,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,721,300.00	1,721,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	430,300.00	430,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,303,200.00	3,399,128.39
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,093,000.00	23,719,200.00
210301	Гэрэл, цахилгаан	5,762,500.00	5,762,500.00
210302	Түлш, халаалт	13,590,500.00	13,590,500.00
210303	Цэвэр, бохир ус	4,740,000.00	4,366,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,830,000.00	2,692,800.00
210401	Бичиг хэрэг	630,600.00	630,600.00
210402	Тээвэр, шатахуун	331,100.00	330,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,500,000.00	1,050,000.00
210404	Ном, хэвлэл	2,368,300.00	682,200.00
2105	Нормативт зардал	375,500.00	375,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	375,500.00	375,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	589,700.00	589,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	89,700.00	89,700.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	500,000.00	500,000.00
2107	Томилолт, зочны зардал	324,600.00	324,600.00
210702	Дотоод албан томилолт	324,600.00	324,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,657,200.00	1,657,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	637,200.00	637,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,000,000.00	-
210807	Газрын төлбөр	1,020,000.00	1,020,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	500,000.00	500,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	500,000.00	500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	500,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	281,576,600.00	279,399,010.39
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	281,576,600.00	279,399,010.39
132001	Орон нутгийн төсвөөс	281,576,600.00	279,399,010.39

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Номын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Буян-Ундрах гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Эрдэнэ, газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах нар тус тус хэрэгжүүлсэн.

Номын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 21-ны өдрийн 08 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Номын төв нь дараах чиг үүргийг хэрэгжүүлдэг. Үүнд:

1. Стандартад нийцсэн орчин нөхцөлд уншигчдад уншлагын үйлчилгээг зохих журмын дагуу хүргэх.
2. Уншигчийг бие даан суралцах, судалгаа хийхэд дэмжлэг үзүүлэх.
3. Соёл олон нийтийн ажлыг зохион байгуулж нийгмийг соён гэгээрүүлэх.
4. Номын сангийн сан хөмрөгийн бүрэн бүтэн байдлыг хангах.
5. Номын сангийн сан хөмрөгийн эргэлтэд байнга судалгаа хийж, бүрдүүлэлтийн чанарыг сайжруулах арга хэмжээг тогтмол зохион байгуулах.
6. Хуучин ном, гар бичмэлийг сурвалжлан олох, нөхөн бүрдүүлэх, олон нийтэд сурталчлах, хадгалах, хамгаалах хэвийн нөхцөлийг хангаж ажиллах.
7. Номын сан, ном зүйн мэдээллийг автоматжуулах, үйл ажиллагаандаа орчин үеийн техник, технологийг нэвтрүүлж, цахим мэдээллийн санг бий болгох.
8. Дотоод, гадаадын номын сан, эрдэм шинжилгээний байгууллагатай хамтран ажиллах.
9. Орхон аймагт үйл ажиллагаа явуулдаг сургууль, соёлын төвүүдийн номын санч нарыг мэргэжил аргазүйн удирдлагаар хангаж ажиллах.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль,
- Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол.
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар батлагдсан Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Номын төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт орлогын 350,607.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 3,506.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 2,454.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

Номын төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 20,057.8 мянган төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	3,841.9	4,524.1	682.2
Үндсэн хөрөнгө	948,471.0	969,846.6	21,375.6
Нийт хөрөнгө	954,709.1	974,766.9	20,057.8
Засгийн газрын хувь оролцоо	954,709.1	974,766.9	20,057.8

Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	954,709.1	974,766.9	20,057.8
--	-----------	-----------	----------

Бараа материалын дансны үлдэгдэл 4,524.1 мянган төгрөг болж 682.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд сонин сэтгүүл худалдан авснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 969,846.6 мянган төгрөг болж 21,375.6 мянган төгрөгөөр өссөн нь 45,831.8 мянган төгрөгийн их засвар хийсэнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 375,663.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 372,720.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 94,086.4 мянган төгрөгөөр бууруулж, улсын төсвөөс 281,576.6 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь улсын төсвийн хөрөнгөөр урсгал зардлыг нэмэгдүүлээгүйтэй холбоотой байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 281,576.6 мянган төгрөгийг улсын төсвөөс олгохоор төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 281,576.6 мянган төгрөгийн санхүүжилт олгож, улсын төсөвт 2,177.6 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 279,399.0 мянган төгрөг буюу 99.2 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд Засаг даргын нөөц сангаас 15,468.8 мянган төгрөг, Соёлын яамнаас 1,250.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, номын баярын үйл ажиллагааны зардалд зарцуулсан байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд цар тахалтай холбоотой хязгаарлалт үргэлжилсэн хэдий ч аудит хийх цар хүрээ хязгаарлагдаагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тус газрын санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудлууд үүсээгүй байна.

3.9 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ШАЛГАСАН НИЙЦЛИЙН АУДИТЫН АСУУДАЛ

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс 148 мэдээллийг хугацаандаа оруулж, 3 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 306,265.3 мянган төгрөгийн орлогын 13 гүйлгээ, өмч хөрөнгө зарцуулахтай холбоотой 3,870.0 мянган төгрөгийн хөрөнгө зарцуулах 6 тушаалыг бүрэн мэдээлсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 139.9 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт бүрэн төлөгдөж, 2 зөвлөмж өгснийг тайлант онд бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

3.11 ДАРААГИЙН АУДИТААР АНХААРАХ АСУУДАЛ

Номын төвийн санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй ба дараагийн аудитаар үндсэн хөрөнгийн дансыг үзэх.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,783.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 300.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 1,483.0 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд залруулсан алдаа байхгүй.

4.2 Төлбөрийн акт

1.Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас ямар нэгэн нотлох баримтгүйгээр 300.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.", 13.7-д "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20.1.4-д "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. **Урсгал зардлын данстай холбоотой асуудал**

1.1. Илрүүлэлт:

Шуудан, холбоо, интернэтийн төлбөрийн зардлаас тоног төхөөрөмжийн үлдэгдэл 250.0 мянган төгрөгийг шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн хуулийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41.2.2-д "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах," гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргаж байх.

2. **Урсгал зардлын данстай холбоотой асуудал**

2.1. Илрүүлэлт:

Тайлант оны үндсэн үйл ажиллагааны орлого 1,233.0 мянган төгрөгийг албан хаагчдын хүүхдүүдэд урамшуулал хэлбэрээр олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 46.3-д "Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг төсвийн хүлээгдэж байгаа гүйцэтгэлд үндэслэн дараах арга хэмжээнд зарцуулж болно:", 46.3.1-д "эх үүсвэр дутагдаж байгаа, эсхүл өр төлбөр үүссэн үндсэн үйл ажиллагааны урсгал зардлыг санхүүжүүлэх;", Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаалаар батлагдсан Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журмын 5.1-д "... журмын дагуу зарцуулах төсвийн хүлээгдэж байгаа гүйцэтгэлд үндэслэн дараах эрэмбийг баримтална.; 5.1.1-д "эх үүсвэр дутагдаж байгаа, эсхүл өр төлбөр үүссэн үндсэн үйл ажиллагааны урсгал зардлыг санхүүжүүлэх," гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг эх үүсвэр дутагдаж байгаа эсхүл өр төлбөр үүссэн үндсэн үйл ажиллагааны урсгал зардлыг санхүүжүүлэх зарцуулж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Номын төв	3	1,783.0	0	0	1	300.0	0	0	2	1,483.0
	Дүн	3	1,783.0	1	0	1	300.0	0	0	0	1,483.0